



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

“Налайх АЗЗА” төрийн өмчит
хувьцаат компанийн 2020 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэх захирал Ц.Баттулгатай байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.“Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Баттулгатай байгуулах контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу 1 жилийн хугацаатай шинэчлэн байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001543